



90

**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ**

2013 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 497

Улаанбаатар хот

Г “Тамхины хор хөнөөлтэй тэмцэх,  
сэргийлэх хөтөлбөр” батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.2, 8.1.21, Тамхины хяналтын тухай хуулийн 4.1.3, 5.1.1 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Тамхины хор хөнөөлтэй тэмцэх, сэргийлэх стратеги”-ийг нэгдүгээр, “Тамхины хор хөнөөлтэй тэмцэх, сэргийлэх стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгах нь:
  - а/ орон нутгийн онцлогт тохирсон “Тамхины хор хөнөөлтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” батлан хэрэгжүүлэх;
  - б/ “Тамхины хяналтын тухай хууль” болон тус стратегийн хэрэгжилтэнд иргэд, олон нийт, байгууллага, бусад салбарын оролцоо, дэмжлэгийг бий болгох, нотолгоонд сууриссан мэдээлэл, сургалт, зөвлөгөө, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;
  - в/ тамхинаас гарах зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээг сум, өрхийн эрүүл мэндийн төвд, утсан зөвлөгөө өгөх үйлчилгээг аймгийн Нийгмийн Эрүүл мэндийн төв, дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлд байгуулан үр дүнд хяналт тавьж ажиллах.
3. Эмнэлгийн орчинг 100 тамхигүй орчин болгож, тамхи татдаг өвчтөнд тамхинаас гарах зөвлөгөө, эмчилгээ явуулах, эмнэлгээр үйлчлүүлэгчдэд тамхины хор хөнөөлийг сурталчлах ажлыг зохион байгуулж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг яамны харьяа тусгай мэргэжлийн эмнэлэг, төвийн дарга нарт даалгасугай.
4. Тус стратегийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв(Л.Насанцэнгэл)-д, хүн амд тамхины хор хөнөөлийг сурталчилах, салбар дундын оролцоог хангах ажлыг эрчимжүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Ө.Ганчимэг), удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс(Д.Нарангэрэл)-т, тамхинаас гарах

Эм, бэлдмэлийн хангамжийг сайжруулахыг Эм, эмнлэгийн хэрэгслийн хэлтэс(Ч.Мөнхдэлгэр)-т, шаардагдах төсвийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвд тусгах арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Д.Төмөрбаатар)-т, стратегийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тамхины хяналтын талаарх үйл ажиллагааны тайлан, үр дүнг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор тус яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт мэдээлж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, яамны харьяа тусгай мэргэжлийн эмнэлэг, төвийн дарга нарт үүрэг болгосугай.

6. Уг стратеги, төлөвлөгөө батлагдаж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны 180 дугаар тушаал хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэндийн сайдын  
оны 11 сарын 30-өдрийн  
497 тоот тушаалын 1 дугаар  
хавсралт

92

## ТАМХИНЫ ХОР ХӨНӨӨЛТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨР

### Нэг.Үндэслэл, шаардлага

Тамхи нь 4400 гаруй химийн хорт бодис, 69 хортой хавдар үүсгэгч химийн бодис агуулж, олон төрлийн хортой хавдар болон халдварт бус өвчнийг үүсгэж, олон сая хүнийг цагаас эрт нас барах, хөдөлмөрийн чадвараа алдах, иргэн, гэр бүлийг эдийн засгийн хохиролд оруулах гол шалтгаан болдог тамхины хэрэглээг бууруулах, тамхины утаанд нэрвэгдэхээс сэргийлэх зорилгоор 2005 оноос эхлэн Тамхины хяналтын суурь конвенци(TXCK)"батлагдан хэрэгжиж байна. Энэхүү конвенцид 2013 оны байдааар дэлхийн 177 орон нэгдэн TXCK, түүнийг дагаж гарсан протокол, удирдамжуудыг удирдлага болгон үндэсний онцлогт тохируулан хууль тогтоомж батлан хэрэгжүүлж байна.

Олон зуун жилээр ноёрхон үндэстэн дамнасан тамхи үйлдвэрлэгчид, худалдаалагчидтай дэлхийн улс орнууд хүчээ нэгтгэн нэгэн зэрэг хүчтэй тэмцлийг явуулж, тамхины бизнес эрхлэгчдийн зах зээлээ өргөтгөх бодлого, арга хэмжээнээс хүн ам, хүүхэд залуучуудын эрүүл мэндийг хамгаалах бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ДЭМБ шаардаж байна. Монгол Улсын Засгийн газраас тус конвенц, түүнийг дагаж гарсан удирдамжийн ерөнхий зарчим, арга хэмжээг дотоодынхоо нөхцөл, байдалтай уялдуулан Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийг 3 удаа шинэчлэн найруулан УИХ-аар батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.

Тамхины хяналтын тухай хуулийн дагуу олон нийт цуглардаг 8 чиглэлийн газарт утаат тамхи татахыг хориглож, тамхины хяналтын талаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тамхи үйлдвэрлэгчийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос хамгаалах, тамхины хяналтын чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг тамхи үйлдвэрлэгчээс хамгаалах, эрүүл мэндийн зурагт анхааруулгын хэмжээг 50-иас доошгүй хувь болгох асуудлыг хуульчилан хэрэгжүүлж байна.

Гэвч тамхины хэрэглээний тархалт дорвитой буурахгүй байгаа нь "Халдварт бус өвчиний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоо шаталсан судалгаа"(2005, 2009, 2013), "Халдварт бус өвчин (ХБӨ)-ий талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгаа" (2009, 2013), "Дэлхий дахини сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа"(2009, 2013) болон эрүүл мэндийн статистик үзүүлэлтээс харагдаж байна. Тухайлбал,

Судалгаагаар<sup>1</sup> нийт хүн амын 27.1 хувь, үүнээс эрэгтэйчүүдийн 49.1 хувь, эмэгтэйчүүдийн 5.3 хувь тамхи татаж байгаа бөгөөд өмнөх судалгаатай харьцуулахад эрэгтэйчүүдийн тамхины хэрэглээ 1.1 хувиар нэмэгдэж,

<sup>1</sup>Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгаа 2013, ЭМЯ, НЭМУТ, ДЭМБ

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ 1.6 ХУВИАР БУУРЧЭЭ. 2010 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 15-24 НАСНЫ ХҮҮХЭД ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ 2.3 ХУВИАР, 45-54 НАСНЫХНЫ ХЭРЭГЛЭЭ 1.8 ХУВИАР ТУС ТУС БУУРСАН БОЛ 25-34 НАСНЫХНЫ ХЭРЭГЛЭЭ 2.3 ХУВИАР ӨСЧ, ӨСВӨР ҮЕИЙНХНЭЭСЭЭ 2 ДАХИН ИХ БАЙГАА НЬ АНХААРАЛ ТАТАЖ БАЙНА.

ТҮҮНЧЛЭН ТАМХИ ХЭРЭГЛЭГЧ 2 ХҮН ТУТМЫН 1 НЬ ГЭРТЭЭ, 3 ХҮН ТУТМЫН 1 НЬ АЖЛЫН БАЙРАНДАА ДАМ ТАМХИДАЛТАД ӨРТӨЖ БАЙГАА НЬ ӨМНӨХ СУДАЛГААТАЙ ХАРЬЦУУЛАХАД ӨӨРЧЛӨЛТГҮЙ, 25-54 НАСНЫХАНЫ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ ~~30 ОРЧИМ ХУВЬТАЙ~~ ТУУШТАЙ БУУРАХГҮЙ БАЙГАА БА БУСАД НАСНЫ БҮЛГИЙНХЭНЭЭС ИХ БАЙГАА ТУЛ ЭНЭ НАСНЫ БҮЛГИЙН ХҮМҮҮСИЙН ДУНД ТАМХИНЫ ХОР ХӨНӨӨЛИЙГ ТАНИУЛАХ, ТАМХИНААС ГАРАХ АРГА ХЭМЖЭЭГ ЭРЧИМТЭЙ ЯВУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА. ТАМХИ ХЭРЭГЛЭГЧДИЙН 9.3 НЬ ТАМХИ ТАТАХАА БОЛИСОН, НИЙТ ХЭРЭГЛЭГЧДИЙН 33 ХУВЬ НЬ ТАМХИ ХАЯХ ЗОРИЛГООР ЭМЧЭЭС ЗӨВЛӨГӨӨ АВСАН ЯЛАНГУЯА 45 –ААС ДЭЭШ НАСНЫХАН ЗӨВЛӨГӨӨГ ИЛҮҮ АВЧ, ТАМХИЧДЫН 42.3% НЬ ТАМХИЙГ ХАЯХ ОРОЛДЛОГО ХИЙСЭН БАЙНА.

ХҮН АМЫН ТАВАН ХҮН ТУТМЫН 1 НЬ (22.1%) ТАМХИНЫ ЭРҮҮЛ МЭНДЭД УЧРУУЛАХ ХОР ХӨНӨӨЛИЙН ТАЛААР ДУТУУ ОЙЛГОЛТТОЙ, ЯЛАНГУЯА 15-24 НАСНЫ ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУД ТАМХИЙГ БАГА ХЭМЖЭЭГЭэр, ХААЯА ХЭРЭГЛЭВЭЛ ЭРҮҮЛ МЭНДЭД ХОР НӨЛӨӨ УЧРУУЛАХГҮЙ ГЭСЭН БУРУУ ОЙЛГОЛТ ТҮГЭЭМЭЛ, ХҮН АМЫН БАРАГ ТАЛ ХУВЬ (49.3%), ЯЛАНГУЯА ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ДУНД ДАМ ТАМХИДАЛТЫН ХОР НӨЛӨӨНӨӨС ӨӨРСДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛАХ ЗЭРЭГ ХАНДЛАГА ДУТМАГ БАЙНА.

2013 ОНЫ “СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУДАЛГАА”-ААР СУДАЛГААНД ХАМРАГДСАН 13-17 НАСНЫ ХҮҮХДИЙН 22 ХУВЬ НЬ ТАМХИ ТАТАЖ БАЙГАА БӨГӨӨД 16-17 НАСНЫ СУРАГЧДЫН 17.5 ХУВЬ СҮҮЛИЙН 30 ХОНОГТ 1-2 ӨДӨР ТАМХИ ТАТАЖ БАЙГАА НЬ 13-15 НАСНЫ СУРАГЧДААС 3 ДАХИН ИХ БАЙГАА НЬ АНХААРАЛ ТАТАЖ БАЙНА. СУДАЛГААНЫ ДҮНГЭЭР 13-15 НАСНЫ СУРАГЧДЫН 5.9 ХУВЬ ТАМХИЙГ 1-2 ӨДӨР ТАТСАН БАЙГАА БА 2010 ОНЫ СУДАЛГААТАЙ ХАРЬЦУУЛАХАД 0.5 ХУВИАР НЭМЭГДСЭН, ҮҮНЭЭС ОХИДЫН ТАМХИ ТАТСАН БАЙДАЛ 1.7 ДАХИН НЭМЭГДЭЖ, ХӨВГҮҮДИЙН 0.9 ХУВИАР БУУРЧЭЭ. ТҮҮНЧЛЭН СҮҮЛИЙН 7 ХОНОГТ СУРАГЧДЫН 61.2 ХУВЬ НЬ ТАМХИНЫ УТААНД ӨРТСӨН БАЙНА.

ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭНД ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛТ ЗАН ҮЙЛ НӨЛӨӨЛӨХӨӨС ГАДНА НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БОЛОХ ТАМХИНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ, ТАМХИ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ХУУЛЬ БУС БУСАД НИЙЛҮҮЛЭЛТ НӨЛӨӨЛДӨГ. ДЭЛХИЙД ТАМХИНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭГЭРЭЭ ТЭРГҮҮЛЭГЧ 2 ТОМ ХӨРШ ОРНЫ ДУНД МАНАЙ УЛС ОРШИН ТОГТНОЖ БАЙГАА БӨГӨӨД ЭДГЭЭР УЛСУУД Ч ТАМХИ ҮЙЛДВЭРЛЭГЧТЭЙ ХАТУУ ТЭМЦЭЛ ЯВУУЛЖ БАЙНА. МАНАЙ УЛСАД ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ЧАНГАТГАЖ БАЙГАА БОЛОВЧ ТАМХИНЫ ИМПОРТ, ҮЙЛДВЭРЛЭЛ БУУРАХГҮЙ, ТЭДНИЙ СӨРӨГ УХУУЛГА СУРТАЛЧИЛГАА ХҮЧТЭЙ ХЭВЭЭР БАЙГААТАЙ ХОЛБООТОЙГООР ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ ДОРВИТОЙ БУУРАХГҮЙ БАЙНА. ТУХАЙЛБАЛ, ТАМХИ ҮЙЛДВЭРЛЭГЧДЭЭС ХҮҮХЭД ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ 11.2 ХУВЬД НЬ ТАМХИ ТАТАЖ ҮЗЭХИЙГ САНАЛ БОЛГОСОН БАЙНА.

УИХ-ААС ТАМХИН БУТЭЭГДЭХҮҮНИЙ ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫГ ДЭС ДАРААТАЙГААР НЭМЭГДҮҮЛЖ, 2012 ОНЫ БАЙДЛААР ТАМХИНЫ ОНЦГОЙ ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ЭХ ОРНЫ БОЛОН ИМПОРТЫН ТАМХИНД НОГДУУЛАХ ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫГ НЭМСЭН Ч БОЛОВЧ ЭНЭ НЬ БУСАД ОРНУУДТАЙ ХАРЬЦУУЛАХАД ТАТВАР БАГА ОРНЫ ТООНД ОРСОН ХЭВЭЭР БАЙНА.

ИЙМЭЭС ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ТАМХИ ҮЙЛДВЭРЛЭГЧИДЭЙ ТЭМЦЭХ, ТАМХИНЫ ХОР УРШГИЙН ТАЛААРХ ХҮН АМЫН МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НИЙГМИЙН САЛБАРУУДЫН ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТАМХИНД ДОНТОХ ЭМГЭГТЭЙ ХҮМҮҮСИЙГ ЭРТ ИЛРҮҮЛЖ ЭМЧЛЭХ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАХИРГААНЫ, ГҮЙЦЭТГЭЛИЙН, БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГ ОЛОН ТАЛТ АЖЛЫН ХҮРЭЭГ ТОГТООН ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА БАЙНА.

## Хоёр: Стратегийн зорилго, зорилт, стратегийн чиглэл:

“Тамхины хяналтын суурь конвенцийн удирдамж, протоколыг удирдлага болгон тамхины хэрэглээг 2025 он гэхэд 25 хувиар бууруулахад энэхүү стратегийн зорилго оршино.

**Стратегийн зорилт 1.** Хүн амын зан үйлтэй холбоотой тамхины эрэлт хэрэгцээг бууруулах, дэмжих орчин бүрдүүлэх;

**Стратегийн зорилт 2.** Тамхины хэрэглээг нэмэгдүүлэх нийгэм эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөг бууруулах замаар тамхины нийлүүлэлтийг багасгах.

### Стратегийн үйл ажиллагааны чиглэл:

1. ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенци /ТХСК/-н заалтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Тамхины хэрэглээг бууруулахад нөлөөлөхүйц татварын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх;
3. Тамхины хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс сайн засаглалын зарчмуудыг (оролцоог хангах, стратегийн алсын хараатай байх, хууль эрх зүй, хариуцлагын тогтолцоо зэрэг) үндэсний болон орон нутгийн түвшинд нэвтрүүлэх;
4. Тамхины хяналтын цогц арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлэхэд оролцогч бүх талуудад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах;
5. Тамхины хяналтын арга хэмжээний төлөвлөлт, нөөцийн менежментийг сайжруулах;
6. Тамхины хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоон чадавхийг сайжруулах;
7. Тамхины хэрэглээ, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийн тандалтын тогтолцоог бий болгох, энэ талаар байгууллага, мэргэжилтний чадавхийг дээшлүүлэх;
8. Тамхины хор хөнөөлийн талаар олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх үр дүнтэй арга хэмжээ авах, энэ ажилд эрүүл мэндийн мэргэжилтнүүд, багш сурган хүмүүжүүлэгчид, бодлого боловсруулагчид, алдартай тамирчид, урлаг, соёлын одуудыг оролцуулах замаар нийгэмд тамхийг үл тэвчих уур амьсгал бий болгох;
9. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд тамхи хэрэглэгчийг илрүүлж, богино хэмжээний зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх.

### Гурав. Стратегийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

Тамхины хяналтыг сайжруулах, хэрэглээг бууруулах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- 3.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогод нийцсэн;
- 3.2. Олон улсын тэргүүний туршлага, шинжлэх ухааны ололт амжилттай уялдсан, улс үндэсний уламжлал, ёс заншилд тулгуурласан;
- 3.3. Тамхины хэрэглээний шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, гарах сөрөг үр дагаврын талаархи судалгаа, нотолгоонд үндэслэгдсэн, энгийн, үр ашигтай;

3.4. Иргэд, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн идэвхтэй оролцоо, түншлэл, нэгдмэл үйл ажиллагаа, ил тод байдалд тулгуурласан;

3.5. Ашиг сонирхлын зөрчил, улс төр, бизнесийн сөрөг нөлөөллөөс ангид байх зарчмыг баримтална.

### **Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа**

Тамхины хор хөнөөлтэй тэмцэх, сэргийлэх стратеги 2014-2020 онд хэрэгжинэ.

### **Тав. Санхүүжилт**

Стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 5.1. улс, орон нутгийн төсөв;
- 5.2. эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө;
- 5.3. иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэд, харьяалалгүй хүнээс үзүүлсэн хандив, тусламжийн хөрөнгө;
- 5.4. Монгол Улсын хууль тогтоомжид үл харшлах бусад орлого.

### **Зургаа . Стратегийн зорилтыг хангах гол үйл ажиллагааны чиглэл:**

1. Хүн амын зан үйтлэй холбоотой тамхины эрэлт хэрэгцээг бууруулах, дэмжих орчин бурдүүлэх нэгдүгээр стратегийн зорилтын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

Тамхины эрэлт хэрэгцээг бууруулах татвар ба үнийг үе шаттайгаар нэмэгдүүлж, тамхины жижиглэнгийн үнийн 50 хүртэлх хувьд хүргэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

1. Тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварын 5-аас доoshгүй хувьтай тэнцэх хөрөнгийг “Эрүүл мэндийг дэмжих сан”-д төвлөрүүлэх эрх зүйн орчин бурдүүлэх замаар сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх;
2. Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрч байгаа хөрөнгийн талаас доoshгүй хувийг тамхины хэрэглээ, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаварыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулдаг болох эрх зүйн орчин бий болгож хэрэгжүүлэх;
3. Тамхины хяналтын хуулийн хүрээнд тамхи татахыг хориглосон ажлын байр, нийтийн тээвэр, олон нийтийн газрууд олон нийт тамхины утаанд өртөхөөс хамгаалсан гүйцэтгэх, захиргааны арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулах;
4. Тамхины бүтээгдэхүүний найрлага, гарах утааны хор холбогдлыг дэлхийн болон үндэсний судалгааны үр дүнд тулгуурласан мэдээлэл, сурталчилгаар шийдвэр гаргагчид, хүн амд хүргэх ажлыг зохион байгуулах;
5. Тамхины үйлдвэрлэл ба хэрэглээнээс гаралтай эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчны сөрөг үр дагаврын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, түүнийг хүртээмжтэй болгох;
6. Тамхины хяналтын тухай хууль, тамхин бүтээгдэхүүнд тавих шаардлага, үндэсний стандартын хэрэгжилтийг хангах ажил зохион байгуулах;
7. Тамхийг сурталчлах, дэмжлэг үзүүлэх ба ивээн тэтгэхэд тавьсан хоригийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах;

8. Тамхин бүтээгдэхүүний шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, эрсдэл, утааны талаарх буруу, төөрөгдүүлсэн, хуурамч ойлголт өгөх зэрэг тамхи үйлдвэрлэгчдээс явуулах сөрөг сурталчлаа, үйл ажиллагаатай тэмцэх;
9. Тамхинаас гарах зөвлөгөө өгөх цогц арга хэмжээг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээгээр дамжуулан хэрэгжүүлэх;
10. Тамхины хамаарлыг эмчлэх үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх, эмчлэх эмийн хангамжийг сайжруулах;
11. Боловсрол, эрүүл мэндийн байгууллага, ажлын байр, биеийн тамир, спортын байгууллагуудад тамхигүй орчин бүрдүүлэх, тамхинаас гарах ажлын байранд түшиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх;
12. Сургуулийн болон оюутан залуучуудын тамхины хэрэглээг бууруулах, тамхинаас гарах арга хэмжээг тогтмол зохион байгуулж, тамхигүй хамт олон болгох хөдөлгөөн өрнүүлэх
13. Тамхи, дам дамхидалтын хор хөнөөлийн талаарх мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх.

#### **Хүрэх үр дүн:**

Тамхины эрэлт, хэрэгцээ буурч тамхигүй ажиллаж, амьдрах хүмүүс, байгууллагын тоо нэмэгдэнэ.

2. Тамхины хэрэглээг нэмэгдүүлэх нийгэм эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөг бууруулах замаар тамхины нийлүүлэлтийг багасгах хоёрдугаар стратегийн зорилтын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1. Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа, үйлдвэрлэл, хуурамч үйлдвэрлэл зэрэг хууль бус худалдааны бүх хэлбэрийг устгах эрх зүйн орчин бүрдүүлж, тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх;
2. Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа, үйлдвэрлэлийг зогсоох, бар кодоор дамжуулан хянан мөрдөх тогтолцоог нэвтрүүлэх;
3. Хууль тогтоомжийн хүрээнд татвар буюу гаалийн татвар төлөөгүй байгаа тамхин бүтээгдэхүүний хадгалалт ба түгээлтийг тандах, баримтжуулах, хянах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
4. Насанд хүрээгүй хүн буюу 21 нас хүрээгүй хүнд тамхин бүтээгдэхүүн худалдаалахыг хориглох хуулийн заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг бусад байгууллага, иргэнд хамт олнотой хамтран хэрэгжүүлэх;
5. Насанд хүрээгүй хүнийг тамхин бүтээгдэхүүнд хүрэх бололцоо олгодог ширхэгээр буюу цөөн ширхэгээр савласан янжуур тамхи зарахыг хориглох заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх.

#### **Хүрэх үр дүн:**

Тамхины хяналтанд оролцогч салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурласан үйл ажиллагаа сайжирч, тамхин бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл буурна.

#### **Долоо. Стратегийн удирдлага, зохион байгуулалт:**

7.1. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх стратегийн хэрэгжилтийн нэгдсэн зохицуулалт, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв хариуцаж, тамхины хяналтын тандалт судалгаа, мэдээ, мэдээллийн сан

байгуулах, хүн амын зан үйлийг өөрчлөх, мэдлэг боловсрол дээшлүүлэх асуудлыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хариуцан хамтран гүйцэтгэнэ.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ТХСК, Тамхины хяналтын тухай хууль, стратегийн хэрэгжилтийн нэгдсэн зохицуулалтыг хариуцах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий салбар дундын Техникийн ажлын хэсэг ажиллана.

7.2. Орон нутгийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл нь тамхины хэрэглээнд нөлөөлж байгаа нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс, ялангуяа тамхины үйлдвэрэл, худалдаа, үйлчилгээ, хяналт, байгууллагуудын оролцоо, хариуцлага зэрэг салбарын дундын оролцоог хангах, үр дүнг тооцох, зохицуулах, гүйцэтгэлийг тайллагнах асуудлыг зохицуулна.

7.3. Аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц дэх Халдварт бус өвчний тандалт, хариу арга хэмжээний нэгж нь тус стратегийн хэрэгжилтийн зохион байгуулалтыг хариуцна.

7.4. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг нэгтгэн дүгнэж, бодлогын шийдвэр гаргана.

#### **Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт:**

8.1. Стратегийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан бусад төрийн захиргааны болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран улсын хэмжээнд, орон нутагт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

98

**Ес. Стратегийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:**

№	Шалгуур үзүүлэлт	Эх үүсвэр	2013 он	2021 он
1.	Хүн амын тамхины хэрэглээний тархалт, хувиар	*	27.1	21.7
2.	Өдөр бүр тамхи хэрэглэгчид, хувиар		24.9	19.9
3.	Тамхины хор хөнөөлийн талаар хангалтгүй ойлголттой хүн ам, хувиар	***	22.1	40.7
4.	Дам тамхидалтын хор хөнөөлийн талаарх хүн амын мэдлэг, хувиар	***	49.3	69.8
5.	Тамхинаас гаражыг оролдсон хүн, хувиар	*	42.3	52.5
6.	Тамхи татахыг больсон хүн, хувиар	*	9.3	15.2
7.	Тамхинаас гарах эмчийн зөвлөгөөнд хамрагдсан хүн ам	*	33.0	60
8.	Сүүлийн 30 хоногт ажлын байран дээрээ тамхины утаанд өртөгсөн хүн ам	*	25.5	20.4
9.	Сүүлийн 30 хоногт гэртээ тамхины утаанд өртөгсөд	*	40.9	34.1
10.	Утаагүй тамхи хэрэглэгчдийн тархалт	*	0.5	0.4
11.	Сүүлийн 30 хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн 13-15 насны хүүхэд, хувиар	**	5.9	4.9
12.	Сүүлийн 30 хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн 16-17 насны хүүхэд, хувиар	**	17.5	14.0
13.	Сүүлийн 7 хоногт тамхины утаанд 1-2 өдөр өртсөн 13-17 сурагчдын хувь	**	61.2	49.0
14.	ДЭМБ-ын “Тамхинаас гарах зөвлөгөө өгөх сургалт”-д хамрагдсан ЭМАШТҮ, хувь		0	60
15.	Тамхины зөвлөгөө өгөх сургагч багшаар бэлтгэгдсэн сургагч багшийн тоо		0	720

**Тайлбар:**

\* ХБΘ, нийтлэг эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоох шатчилсан судалгаа, 2013 он

\*\* Дэлхийн сургуульд сууринсан хүүхдийн эрүүл мэндийн судалгаа, 2013 он

\*\*\* Халдварт бус өвчний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгаа, 2013 он

Эрүүл мэндийн сайдын  
оньш сарын 30-өдрийн  
497-дугаар тушаалтын 2 дугаар  
хавсралт

ТАМХИНЫ ХОР ХӨНӨӨЛТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ СТРАТЕГИЙГ ХЭРЭГКҮҮЛЭХ  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, 2014-2020 ОН

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллага	Шалгуур үзүүлэлт	
<b>Стратегийн чиглэл1. ДЭМБ-ЫН Тамхинны хяналтын суурь конвенци /ТХСК-/н заалтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр Бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох</b>						
<b>Үр дүн:</b> ДЭМБ-ЫН ТХСК-ийг хэрэгжүүлэх талаар гарсан удирдамжуудад тусгасан заалт, зөвлөмжийг үндэсний хууль тогтоомжид тусган тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.						
1.1.	Тамхини хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	2015	ЭМЯ	Ажлын хэсэг	Хуулийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлсэн байна.	
1.2.	Хөдөлгөрлийн харилцаатай холбогдсон хууль, эрх зүйн баримт бичиг, дотоод журамд ажлын байранд тамхи татахыг хориглосон зүйл, заалт тусгах асуудлыг эрчимжүүлэх	2014-2015	МАОЭНХ (Монголын ажилт олгогч эздин нэгдсэн холбоо)	ХАХНХЯ МҮЭНХ ЭМЯ	Тамхи татахыг хориглосон заалт бүхий хууль, эрх зүйн баримт бичиг	
1.3	Навчийн тамхини техникийн өрөнхий шаардлага-үндэсний стандарт, техникийн зохицуулалтыг боловсронгуй болгох	2013-2014	ҮХДАЯЯ, ЭМЯ	СХЗГ, Ажлын хэсэг	МХЕГ, ГХЯ ГЕГ	Батлагдсан стандарт, техникийн зохицуулалт
1.4.	Тамхин бүтээгдэхүүний шинжилгээний аргын олон улсын стандартуудыг үндэсний болгох, дахин хянах, баталгаажуулж мөрдүүлэх	2014-2015	СХЗГ ҮХДАЯЯ	ЭМЯ, ГЕГ	МХЕГ, ГЕГ	Батлагдсан стандарт
1.5.	ТХСК-ЫН Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барих	2014	ЭМЯ,ХЗЯ,	ЭМЯ	Хуулийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж соёрхон баталсан байна.	

1.6.	Барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан систем болгох мөрдүүлэх Тамхинь хайрцааг, боодол дээр хэвлэх эруул мэндийн зурагтай анхаарууллыг шинэчлэн боловсруулж батлуулах, тамхин бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагагүндэсний стандартад тусгах	2014-2015 ГЕГ ЭМЯ СХЗГ	2014-2015 ГЕГ ЭМЯ СХЗГ	МХЕГ, СХЗГ Тамхинь аngilal шинэчлэгдсэн байна. Шинэчлэгдэж батлагдсан загвар, стандарт			
1.7.	Электрон Тамхинь хэрэглээг хянах, импортох, үйлдвэрлэхийг хориглох эрх зүйн орчин бурдүүлэх	2015-2020 ЭМЯ	2015-2020 ЭМЯ	ЭЗХЯ, УХАДАЯ Хууль эрх зүйн орчин бурдсэн байна.			
1.8.	<b>Стратегийн чиглэл 2.</b> Тамхинь онцгой албан татварын жилийгтэн худалдаалах үнэд эзлэх хувийн жинг 60%-д хүргэх талаар тодорхой Үр дүн:	Тамхинь онцгой албан татварын жилийгтэн худалдаалах үнэд эзлэх хувийн жинг 60%-д хүргэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.					
<b>2.1.</b> Тамхинь татварын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх чиглэээр ухуулга нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, энэ талаар Сантийн яам, холбогдох бусад байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах							
<b>2.2.</b> Тамхин бүтээгдэхүүнд ногдох онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлэх талаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж Засгийн газар, УИХ-д оруулж шийдвэрлүүлэх							
<b>2.3.</b> Тамхин бүтээгдэхүүний одоогийн зах зээлийн үнэ, татварын тогтолцоог судлан бодлогын түвшинд хувилбар боломжтой хэрэгжүүлэх							
<b>2.4.</b> Тамхин бүтээгдэхүүний татварын тооцоолол хийх талаар гадаадын сургалтад хүн явуулах, зөвлөх уржж ажиллуулах							
<b>2.5.</b> Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх протоколыг хэрэгжилтийг хангах, сурталчлах							

700

**Стратегийн чиглэл 3.** Тамхини хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс сайн засаглалын зарчмуудыг (оролцоог хангах стратегийн алсын харалтай байх, хууль эрх зүй, хариуцлагын тогтолцоо зэрэг) үндэсний болон орон нутгийн түвшинд нэвтрүүлэх үндэсний болон орон нутгийн түвшинд зохицуулах механизмын чадавхи сайжирч сайн засаглалын зарчмууд

**Үр дүн:**

3.1.	Тамхини хяналтын салбар дундын асуудал хариуцсан НЭМСЗ, НЭМТ-ийн ХБӨ-ний тандалт, хариу арга хэмжээний НЭРГ, ЭМЯ-ны техникийн ажлын хэсгийг байгуулах, чадавхижуулах, үйл ажиллагааны уялдааг хангах	2014-2015	ЭМЯ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, ЭМГ	ЭМЯ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, ЭМГ	ЭМЯ, Тамхини хяналтын салбар дундын ажлын хэсэг	ЭМЯ, Тамхини хяналтын салбар дундын ажлын хэсэг	Байгуулсан аймаг, дуургийн хувь
3.2.	Тамхини хяналтыг хэрэгжүүлэх үндэсний зохицуулах механизмыг сайжруулах	2014-2016	ЭМЯ, СЭМУТ	ДЭМБ	ДЭМБ	Х3Я, МХЕГ, ШӨХТГ,	ДЭМБ-ын зөвлөмж, хэрэгжүүлсэн хэмжээний тайллан
3.3.	Хууль, хяналтын байгууллага, орон нутгийн захирагааны байгууллага, хэрэглэгчийн төлөх газар, МХЕГ, ШӨХТГ,ХЭАХГ зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрзэ байгуулан ажиллаж тамхини хяналтын хууль тогтоомжид тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2014-2020	ЭМЯ, НЭМУТ	ЭМЯ, НЭМУТ	Х3Я, МХЕГ, ШӨХТГ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, МХГ	Аймаг, Нийслэлийн ЗДТГ, МХГ	Аймаг, арга тайллан, гарсан үр дүн
3.4.	Тамхини хяналтыг сайжруулахад сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлсэн ажлын туршлагыг аймаг, Нийслэлд нэвтрүүлэх чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах	2014-2020	ЭМЯ СЭМУТ, НЭМУТ	ЭМЯ СЭМУТ, НЭМУТ	Аймаг, Нийслэлийн ЗДТГ	Тэргүүн нэвтрүүлсэн дүүрэг, байгууллага, аж ахуйн нэгжийн хувь	Тэргүүн нэвтрүүлсэн дүүрэг, байгууллага, аж ахуйн нэгжийн хувь
3.5.	Тамхини худалдааг тусгай зөвшөөрөлтэй болгох талаар шийдвэр гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, тамхи худалдаалж байгаа цэгт тавих шаардлагын талаар заавар зөвлөмж гаргаж хэрэгжүүлэх, сургарт, семинар зохион байгуулах	2014- 2020	ЭМЯ Аймаг, Нийслэл, Сум, Дуургийн ЗДТГ, МХГ	МХЕГ, ГХЯ, ЭМЯ	МХЕГ, ГХЯ, ЭМЯ	Тамхини худалдааг тусгай зөвшөөрөлтэй болгосон аймаг, сум, дуургийн хувь	Тамхини худалдааг тусгай зөвшөөрөлтэй болгосон аймаг, сум, дуургийн хувь
3.6.	Төрийн бух шатны байгууллага, төрийн албан хаагчид тамхини үйлдвэртэй харилцах харилцаа, хэмжээний талаар дүрэм/журам гаргаж мөрдүүлэх, холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд тусгуулах арга хэмжээ авах	2014-2016	ЭМЯ СЭМУТ НЭМУТ	Х3Я, ТББ	Батлагдсан дүрэм/журам, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Батлагдсан дүрэм/журам, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	

70

3.7.	100 хувь Тамхигүй орчин бурдүүлэх хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	2014-2020	Байгууллагаа ж ахуйн Нэгжийн захирагаа	НЭМҮТ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, ЭМГ	100 хувь Тамхигүй бурдүүлэх дотоод тусаж ЕБС, бусад байгууллага, аж ахуйн Нэгжийн хувь
3.8.	100 хувь Тамхигүй орчин бурдүүлсэн, Тамхи татагчдыг тамхинаас гаргасан, Дэмжсан байгууллага, хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэн шалгаруулж туршлагыг нийтэд сурталчлах, сүлжээ бий болгох	2014-2020	ЭМЯ НЭМҮТ	Аймаг, Нийслэлийн ЗДТГ, ЭМГ	100 хувь Тамхигүй бурдүүлсэн, Тамхигүй байгууллага, хамт олны сүлжээ
3.9.	Ядуу, эмзэг булгийн хүн ам, хүүхэд өсвөр үе, охид, эмэгтэйчүүд, эрчүүдэд зориулсан Тамхинь хянаптын хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлэх, Тэдний оролцоог Нэмэгдүүлэх	2014-2020	ЭМЯ СЭМҮТ НЭМҮТ Орон нутгийн байгууллагууд	ХАХНХЯ Аймаг, Нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ТББ	Хэрэгжүүлсэн өвөрмөц хөтөлбөр, үйл ажиллагааны тайлан
3.10.	ДЭМБ-ын ТХСК-ийг хэрэгжүүлэх талаар гарсан явгуулах удирдамж, протоколын талаар сургалт, сурталчилгаа явгуулах	2014-2020	ЭМЯ	СЭМҮТ НЭМҮТ НЭМХ, ТББ	Сургалт, сурталчилгааны тайлан
3.11.	Тамхинь хянаптын салбар дундын техникийн ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж мэдээлэл солицсон тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэн зөвлөмж/чиглэл гаргаж ажиллах, арга хэмжээг анхан шатанд төлөвлөх, санал боловсруулж шийдвэрлүүлэх, мэдээний сан байгуулж ажиллуулах	3Г 191 тоогоолын дагуу	УХААЯ, ГХЯ,ХЗЯ, СЯ,СХЗГ, МХЕГ, ШӨХТГ, ГЕГ, ТЕГ	Уулзалтаас гарсан зөвлөмж/чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	
3.12.	Тамхинь хянаптын талаар холбогдох Яам, агентлаг ажлын тайланг Нэгтгэн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэпцуулэн Засгийн газарт танилцуулж байх	Жил бурийн II ул	ЭМЯ	НЭМҮТ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, ЭМГ	Үйл ажиллагааны тайлан, түүнд өгсөн чиглэл, зөвлөмж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
3.13.	ДЭМБ-ын ТХСК-ийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлын тайланг холбогдох байгууллагуудтай хамтран гаргаж Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт явгуулах	2 жил тутамд	ЭМЯ ДЭМБ	БШУЯ, СЯ, ГХЯ, УХААЯ, МХЕГ, ТЕГ, ГЕГ, СХЗГ	Загвар асуумжийн дагуу хийсэн тайлан

102

**Стратегийн чиглэл 4.** Тамхини хяналтын цогц арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлэхэд оролцогч бүх талуудад мэргэжил, арга зүйн дэлжилгээг узүүлж хамтарч ажиллах  
Тамхини хяналтын чиглэлээр бусад салбарын яам, агентлаг, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, иргэд, хамт огны үйл ажиллагаанд дэлжилгээг узүүлж хамтарч ажиллах талаар ахиц дэвшүүлж гарсан байна.

**Үр дүн:**

4.1.	Хамтран ажиллагааны чиглэл, чадавхи, узүүлж болох нэлheeийн түвшнээр нь тодорхойлсон судалгаа гаргаж, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тулгамсан асуудлын талаар мэдээлэл солилцож хамтран ажиллах, үйл ажиллагаанд нь дэлжилгээг узүүлэх, оруулсан хувь нэмрийг нь үнэлэн олон нийтэд сурталчлаах	Хамтран ажиллагаач/сонирхогч талуудыг түвшнээр нь тодорхойлсон судалгаа гаргаж, хэрэгжүүлж мэдээлэл солилцож хамтран ажиллах, үйл ажиллагаанд нь дэлжилгээг узүүлэх, оруулсан хувь нэмрийг нь үнэлэн олон нийтэд сурталчлаах	Үйл 2014-2020 ЭМЯ НЭМУТ СЭМУТ	НЭМУТ СЭМУТ	Хамтран ажиллагч/сонирхогч талуудын судалгаа, Үйл тайлан
4.2.	Аж ахуйн нэгж, байгууллага /сургууль, ажлын байр, эмнэлэг зэрэг/-д тамхигийн орчин бурдуулж байгаа ажилд дэлжилгээг узүүлэх, сургалт, семинар зохион байгуулж арга зүйн зөвлөгөө, дэлжилгээг узүүлэх	Жил бүр СЭМУТ НЭМУТ	СЭМУТ, ХСҮТ Аймаг, Нийслэлийн ЗДТГазар ЭМГ	СЭМУТ, ХСҮТ Аймаг, Нийслэлийн ЗДТГазар ЭМГ	Үйл тайлан
4.3.	“Тамхигүй орчин” болゾолт уралдаан зарлаж дүгнэх, тамхигүй орчин бурдуулсэн байгууллага, хамт олныг сурталчлах, туршлагыг түгээх	2 жиол тутамд	ЭМЯ, Аймаг, Нийслэлийн ЗДТГазар	Бшуя, ХАХНХЯ, Хэвлэл, мэдээллийн байгууллага	Тамхигүй бурдуулсэн байгууллага, аж ахуйн нэгжийн хувь, Сургалчилж туршлагыг түгээсэн байгууллага, хамт олны хувь
4.4.	Тамхини хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих арга зүйн талаар улсын байцаагч, цагдаагийн ажилтан, захирагааны ажилтан нарт зориулсан сургалт зохион байгуулах	2014-2020 МХЕГ	ЭМЯ, УХААЯ, ГХЯ, ТЕГ, ГЕГ, ШӨХТГ	Сургалтад хамрагдсан байцаагчдын хувь	
4.5.	“Тамхигүй орчин” дэлжигч байгууллага, Эрүүл хот, аймаг, сум, ажлын байр” хөтөлбөрийг аж ахуй нэж байгууллагуудад хэрэгжүүлэх	Жил бүр	ЭМЯ МАОЭНХ Аймаг, Нийслэлийн ЗДТГ	НЭМУТ СЭМУТ,	Тамхигүй бурдуулсэн аж ахуй нэгжийн хувь

103

4.6.	Тамхини хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын туншлэлийг бэхжүүлэх талаар уулзант, сургалт зохион байгуулах	Тамхини хяналтын ажилтнуудад сургалт үйлчилгээг гэрээзэр гүйцэтгүүлэх, чадавхийг бэхжүүлэх	Жил бүр	ЭМЯ СЭМҮТ НЭМҮТ	МАОЭНХ	2011-2014	Үйл ажиллагааны тайлан	
4.7.	Тамхини хяналтын талаар ТББ-ын удирдлага, ажилтнуудад сургалт яввуулж хамтран ажиллах, ажилт үйлчилгээг гэрээзэр гүйцэтгүүлэх, чадавхийг бэхжүүлэх	Тамхини хяналтын талаар холбогдох байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож нэгдсэн тайлан, мэдээллийг Дэлхийн тамхини хяналтын мэдээлэлд туслуулж байх	Тухай бүр	ЭМЯ ДЭМБ	ТББ	Сургалт, ажиллагааны тайлан	Үйл ажиллагааны тайлан	
4.8.	Дам тамхидалтын хор уршиг, тамхигүй орчин бурдуулэх арга зүйн талаар гарын авлага, сурталчилгааны материал боловсруулж хэвлүүлэх, түгэх, мэдээлэл, сурталчилгaa явуулах	Дам тамхидалтын хор уршиг, тамхигүй орчин бурдуулэх арга зүйн талаар гарын авлага, сурталчилгааны материал боловсруулж хэвлүүлэх, түгэх, мэдээлэл, сурталчилгaa явуулах	Жил бүр	ЭМЯ НЭМҮТ, СЭМҮТ, ХСҮТ	ЭМЯ СЭМҮТ НЭМҮТ	СЯ, ҮХААЯА, БШУЯА, ГЕГ, МХЕГ, УСГ, ТББ	Сяя, ГХЯ, ҮХААЯА, БШУЯА, ТЕГ, ГЕГ, МХЕГ, УСГ, ТББ	Дэлхийн хяналтын мэдээллийн тогтолцоонд оруулахаар явуулсан мэдээлэл, үйл ажиллагааны тайлан
4.9.	Тамхини хор хөнөөл, дам тамхидалтын хор уршиг, урлаг, соёл, спорт бусад олон нийтийн дунд явуулах арга хэмжээг тамхигүй зохион байгуулах талаар спорт, урлаг, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах ажилтан, Тамирчид, Жүжигчид, сурвалжлагч наратай уулзант хийх, сургалт, семинар зохион байгуулах	Тамхини хор хөнөөл, дам тамхидалтын хор уршиг, урлаг, соёл, спорт бусад олон нийтийн дунд явуулах арга хэмжээнд тамхини үйлдвэрээс аливаа төрлийн хандив, тусламж, дэмжлэг авахгүй, түүн дээр тамхи татахгүй, тамхийг сурталчлахгүй байх хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж хэвшүүлэх	Жил бүр	ЭМЯ СЭМҮТ, ССАЖЯ, ЭМШУИС, ТББ	ЭМЯ СЭМҮТ, ССАЖЯ, ЭМШУИС, ТББ	БШУЯА, ССАЖЯ, ЭМШУИС, ТББ	Гарын авлага, сурталчилгааны материа-лаар хангадсан байгууллагын хувь	Гарын авлага, сурталчилгааны материа-лаар хангадсан байгууллагын хувь
4.10.	Урлаг, соёл, спорт бусад олон нийтийн дунд явуулах хандив, тусламж, дэмжлэг авахгүй, түүн дээр тамхи татахгүй, тамхийг сурталчлахгүй байх хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж хэвшүүлэх	Тамхини хор хөнөөл, дам тамхидалтын хор уршиг, урлаг, соёл, спорт бусад олон нийтийн дунд явуулах арга хэмжээнд тамхини үйлдвэрээс аливаа төрлийн хандив, тусламж, дэмжлэг авахгүй, түүн дээр тамхи татахгүй, тамхийг сурталчлахгүй байх хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж хэвшүүлэх	2011-2014	ССАЖЯ БШУЯА, ЭМЯ,	2014-2020	ССАЖЯ БШУЯА, ЭМЯ,	Урлаг, соёл, спорт бусад олон нийтийн дунд явуулах хандив, тусламж, дэмжлэг авахгүй, түүн дээр тамхи татахгүй, тамхийг сурталчлахгүй байх хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж хэвшүүлэх	Сургалт, семинарт оролцсон спорт, урлаг, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны хувь
4.11.	Тамхи татдагчийг, түүгээр үйлчилдэгчийг өдөртэй болсон Нийслэл хот болон зарим аймаг, сумдын туршиллагыг бусад аймаг, хотод нэвтрүүлэх, дэмжлэг үзүүлэх	Тамхи татдагчийг, түүгээр үйлчилдэгчийг өдөртэй болсон Нийслэл хот болон зарим аймаг, сумдын туршиллагыг бусад аймаг, хотод нэвтрүүлэх, дэмжлэг үзүүлэх	2014-2020	ЭМЯ, НЭМҮТ	ЭМЯ, НЭМҮТ	АЙМАГ, Нийслэлийн ЗДТГ	Тамхи татдагчийг, түүгээр үйлчилдэгчийг өдөртэй болсон аймаг, дүүртийн хувь	
4.12.								

102

4.13.	Хамтран ажиллагч/оролцогч байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, хамт олонд зориулан тамхины үйлдвэр 2014-2020	НЭМҮТ СЭМҮТ	НЭМҮТ Тамхины хяналтын салбар дундын ажлын хэсэг	Боловсруулсан удирдамж/зөвлөмж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
4.14.	Үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг үнэлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх зорилгоор хамтрагч болон сонирхогч талуудын оролцоог бүрэн хангасан олон салбарын төлөөлөл бүхий улзалт, зөвлөгөөн зохион байгуулах	Жил бүр	ЭМЯ Тамхины хяналтын салбар дундын ТАХ	Улзааг/зөвлөгөөнөе с гарсан чиглэл, зөвлөмж, хэрэгжүүлсэн арга хэмжээ
<b>Стратегийн чиглэл 5. Тамхины хяналтын арга хэмжээний төлөвлөлт, нөөцийн менежментийг сайжруулах Үр дүн:</b>				
5.1.	Үндэсний болон орон нутгийн түвшинчд зарцуулах хөрөнгө нэмэгдэж төлөвлөлт, нөөцийн менежмент сайжирсан байна. Тамхины хяналтын арга хэмжээнд зарцуулах хөрөнгө нэмэгдэж төлөвлөлт, нөөцийн менежмент сайжирсан байна. Хяналтын хөтөлбөрт зарцуулах хөрөнгийн эх чусвэр, хэмжээг тодорхойлох судалгаа явуулж шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, энэ талаар ДЭМБ-аас техник, арга зүйн туспалцаа авах	2014-2018	ЭМЯ НЭМХ	Судалгааны тайлан, зөвлөмж
5.2.	Тамхины хяналтын арга хэмжээг эх, хүүхэд, нөхөн 2012-2014	ЭМЯ НЭМҮТ СЭМҮТ, ХСҮТ	ЭЗХЯ, ХАХНХЯ, ДЭМБ, НҮБ-ЫН Хөгжлийн хөтөлбөр, Хүүхдийн сан, Хүн амын ТББ	Бусад хөтөлбөр, төсөл, үйл ажиллагаатай улдуулан зохион байгуулсан арга хэмжээний өсөлтийн хувь
5.3.	Орон нутагт төлөвлөлтийг оновчтой болгож орон нутгийн төсөв, Эрүүл мэндийг дэмжих сангаас үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх	2014-2020	Аймаг, Нийслэлийн ЗДТГ, ИТХ, ЭМГ	Орон нутагт явуулах тамхин, хяналтын арга зарцуулсан санхүүжилтийн хэмжээний өсөлтийн хувь

5.4.	Тамхинд донтох өвчний эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлыг судлан ажиллаж санал боловсруулан шийдвэрлүүлэх	2015-2018	ЭМЯ, СЭМУТ	ҮНДЕГ ЭРҮҮЛ МЭНДИЙН даатгалын сан	Гарсан шийдвэр
5.5.	Хамт олныхоо дунд тамхини хяналтын талаар сургалт, сурталчилгаа явуулах, тамхигүй орчин бурдүүлэх талаар тодорхой арга хэмжээг төлөвлөн санхүүжүүлэх арга хэмжээ авах	2014-2020	Яам, агентлаг, байгууллага, аж ахуйн нэгж	Аймаг, Нийслэлийн ЭМГ Тамхины хяналтын талаар төлөвлөгөө, тусгасан Яам, агентлаг, байгууллага, аж ахуйн нэгжийн хувь	
5.6.	Тамхини үйлдвэртэй холбоогүй гадаад, дотоодын хандивлагч байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус болон санхүүгийн байгууллагад хандаж тамхини хяналтын үйл ажиллагааг нэмэлттээр санхүүжүүлэх боломжийг судлах	2014-2016	ЭМЯ	НЭМУТ	Судалгааны танилцуулга
<b>Стратегийн чиглэл 6. Тамхини хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхдэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоон 50-иас доошгүй хувийг сургалтад хамруулсан сайжруулах</b>					
<b>Үр дүн:</b> Тамхини хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тогтоон 50-иас доошгүй хувийг сургалтад хамруулсан байна.					
6.1.	Тамхини хяналтын чиглэлээр ажиллаж байгаа хүний нөөцийн судалгаа гаргаж цаашдын хэрэгцээг тодорхойлох, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, энэ талаар ДЭМБ-аас техник, арга зүйн туслацаа авах	2014-2015	ЭМЯ	НЭМУТ ДЭМБ	Судалгааны тайлан, боловсруулсан төлөвлөгөө
6.2.	Тамхини хяналтын манлайлал болон MPOWER-бодлогын багцаар сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж хэвлүүлэн сургалт явуулах	2014-2020	ЭМЯ НЭМУТ СЭМУТ ХСҮТ	ДЭМБ	Боловсруулж хэвлүүлсэн сургалтын хөтөлбөр, гарын авлага
6.3.	Эрүүл мэндийн мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөрийг хянан Узэж тамхини хяналтын асуудлыг тусгах/шинэчлэн боловсронгуй болгох	2015-2018	ЭМЯ	БШУЯА ЭМШУИС АҮК	Тамхини хяналтын талаар хөтөлбөртөө тусгасан сургуулийн хувь

106

6.4.	Тамхинны хяналтын манлайлал, MPOWER-бодлогын багц хөтөлбөрөөр төр, захирагаа, хууль, хяналт, хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан, эмч, багш, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн сургалтын арга зүйч, нийтийн ажилтан, холбогдох салбарын мэргэжилтнуудэд дахин сургалт явуулах	2014-2020	ЭМЯ НЭМҮТ, СЭМҮТ	БШУЯ, АЙМАГ, Нийслэлийн ЗДТГ, БСГ, ЭМГ, ДЭМБ	Сургалтын тайлан, хамрагдсан багш, мэргэжилтний хувь
6.5.	Тамхинны хяналтын манлайллын талаар гадаад орнуудад зохион байгуулагдах сургалт, семинарт хүн оролцуулах	Тухай бүр	ЭМЯ	ДЭМБ, бусад ОУБ, хандивлагч орон	Сургалтад хамрагдсан хувь
<b>Стратегийн чиглэл 7.</b> Тамхинны хэрэглээ, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийн тандалтын тогтолцоог бий болгох, энэ талаар байгууллага, мэргэжилтний мэргэжилтний чадавхийг дээшшуулэх					
Тамхинны хэрэглээ, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийн тандалтын тогтолцоо бий болж байгууллага, мэргэжилтний чадавхи дээшилсэн байна.					
7.1.	Хүүхэд, запуучууд нийт хүн амын тамхини хэрэглээний байдалд тандалт судалгааг тогтмол хугацаанд явуулах	2017-2021	ЭМЯ НЭМҮТ	ДЭМБ, НЭМҮТ	Судалгааны тайлан
7.2.	Тамхинаас үүдэлтэй өвчлөл, нас бараалтын өртөг зардлын судалгаа явуулах	2015-2018	ЭМЯ НЭМХ НЭМҮТ	ЭМШУИС-ийн НЭМС, СЭМҮТ, ДЭМБ	Судалгааны тайлан
7.3.	Үндэсний хэмжээнд тамхини хэрэглээний талаарх мэдээлэл цуглуулах, мэдээлэх аргачлал боловсруулж, мэдээний сан байгуулж, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг сургах	2014-2016	НЭМҮТ	НЭМҮТ АЙМАГ, Нийслэлийн ЭМГ	Батлагдсан аргачлал, Сургалтад хамрагдсан нийгмийн эрүүл мэндийн ажилтны хувь
7.4.	Тамхини хэрэглээний талаарх мэдээллийг үндэсний статистик үзүүлэлтэд тусгах боломжийг судалж санал боловсруулах	2014-2015	ЭМЯ НЭМҮТ	НЭМҮТ ҮСХ	Гарсан санаал, танилцуулга
7.5.	Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр цуглуулдаг тамхинаас үүдэлтэй өвчлөл, нас баралтын үзүүлэлтүүдэд үнэлгээ дүгнэлт хийж, боловсронгуй болгох	2014-2015	ЭМЯ НЭМҮТ	ҮСХ, НЭМҮТ	Шинэчлэгдэн батлагдсан үзүүлэлт
7.6.	Тамхини хэрэглээний тандалт, мэдлэгийн менежментийн талаар сургалт явуулах	2014- 2020	ЭМЯ НЭМҮТ	НЭМҮТ	Сургалтын тайлан

107

7.7.	Тамхинь хяналтын үйл ажиллагааны үр дүнгийн талаар судалгаа явуулах	2017-2021	ЭМЯ НЭМҮТ СЭМҮТ	Эмшиүис-ийн НЭМС, ТББ	Судалгааны тайлан
7.8.	Тамхинь үйлдвэрийн үйл ажиллагааг хянах стратеги боловсруулж хэрэгжүүлэх	2014-2015	ЭМЯ НЭМҮТ СЭМҮТ	НЭМҮТ МХЕГ ҮХАЯЯ, ГХЯ, СХЗГ	Батлагдсан стратеги
7.9.	Тамхинь хэрэглээнээс хүний эрүүл мэнд, айл өрх, улс орны эдийн засаг, байгаль, орчинд учруулах сөргөт үр дагавар, тамхинь хяналтын арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар мэдээллийн сантай болох, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нар болон олон нийтэд зориулсан мэдээллийг тогтолжуулах	2015-2016	ЭМЯ НЭМҮТ СЭМҮТ	БШУЯЯ, СЯ, БОНХЯЯ, Эмшиүис-ийн НЭМС, ТББ	Судалгааны тайлан, Мэдээллийн сан, түүний ажиллагааны тайлан
7.10.	Тамхинь хэрэглээнээс хүний эрүүл мэнд, айл өрх, улс орны эдийн засаг, байгаль, орчинд учруулах сөргөт үр дагавар, тамхинь хяналтын арга хэмжээний үр дүнгийн талаар эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах	2016 2020	ЭМЯ НЭМҮТ	ДЭМБ СЭМҮТ	Бага материалын хураангуй хэвлэгдсэн байна.
7.11.	Хүн амын тамхинь хэрэглээ-өвчлөл, эдийн засгийн сөргөт нөлөөллийн талаар судалгаа хийх	2015-2020	НЭМҮТ СЭМҮТ	ЭМЯ, НЭМХ	Судалгааны тайлан
	<b>Стратегийн чиглэл 8.</b> Тамхинь хор хөнөөлийн талаар олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшшуулэх үр дүнтэй арга хэмжээ авах, энэ ажилд эрүүл мэндийн мэргэжилтнүүд, багш сурган хумуужуулэгчид, бодлого боловсруулагчид, алдартай тамирчид, урлаг, соёлын одуудыг оролцуулах замаар нийгэмд тامхийг үл тэвчих уур амьстгал бий болгох				
	<b>Үр дун:</b> Тамхинь хор хөнөөлийн талаар олон нийтийн мэдлэг, хандлага дээшлэн нийгэмд тамхийг үл тэвчих уур амьстгал бий болно				
8.1.	Сургууль, соёл, эрүүл мэндийн байгууллага, бусад бурдүүлэх аж ахуйн нэгжид тамхилуй орчин тамхинаас гаргах сургалт, семинар зохион байгуулж арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	2014-2020	ЭМЯ ССАЖЯ	БШУЯЯ, ХАХНХЯ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ХХУГ, БСГ, ТББ	Тамхигүй орчин бий болгосон байгууллага, аж ахуйн нэгжийн хувь
8.2.	Тамхигүй орчин бурдүүлсэн, тамхи татдаг хүнгүй болсон байгууллага, хамт олныг сурталчлах, туршлагыг түгээх	2014-2020	ЭМЯ, Аймаг, Нийслэлийн ЗДТГазар	БШУЯЯ, ХАХНХЯ, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл	Сурталчилж туршлагыг түгээсэн байгууллага, олны хувь

8.3.	Тамхини хэрэглээ, дам тамхидалтын хор хөнөөл, урлаг, соёл, спорт бусад олон нийтийн дунд явуулах арга хэмжээг тамхигүй зохион байгуулах талаар спорт, урлаг, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах ажилтан, сурвалжлагч, тамирчид, жүжигчидтэй уулзалт хийх, сургалт, семинар зохион байгуулах, хамтарч ажиллах	2014-2020	ЭМЯ ССАЖЯ	БШУЯ, ССАЖЯ, НЭМҮТ СЭМҮТ ЭМШУИС, ТББ	Тамхигүй зохион байгуулсан урлаг, соёл, спорт бусад олон нийтийн хэмжээний хувь
8.4.	Тамхи татдагчий, түүгээр үйлчилдэгчий өдөртэй болсон Нийслэл хот болон зарим аймитийн туршлагыг бусад аймаг, хотод сурталчлан нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	2014-2020	НЭМҮТ СЭМҮТ	АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ	Тамхи татдагчий түүгээр үйлчилдэгчий болсон өдөртэй аймаг, дүүргийн хувь
8.5.	Тамхини хор хөнөөл, тамхини үйлдвэрийн бодлого, Үйл ажиллагааны мөн чанар, хууль тоогоомж зөрчсөн тохиолдлыг цаг алдаалж мэдээлж байх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгаа явуулах	Жил бүр	ЭМЯ, НЭМҮТ	МУОНТР, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БУСАД БАЙГУУЛЛАГА	Тамхини хяналтын талаар нийтлэл, нэвтрүүлэг тогтолц болж хэвшсэн сонин, хэвлэл, ТВ, FM, радиогийн хувь
8.6.	Тамхини хор хөнөөл, талаар ЕБС-ийн эруул мэнд, биологии, нийгмийн ухааны сургалтын агуулга, хөтөлбөрт тусгагдсан үнэлгээ хийн шаардлагатай арга хэмжээ авах	2012-2013	БШУЯ	ЭМЯ НЭМҮТ, СЭМҮТ	Үнэлгээ, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
8.7.	ЕБС-д эруул мэнд, биологии, нийгмийн ухааны хичээл заадаг багш, сургуулийн нийгмийн ажилтнуудад арга зүйн сургалт явуулах	2014-2018	БШУЯ	ЭМЯ НЭМҮТ, ХСҮТ, СЭМҮТ	Сургалтын тайлан, сургалтад хамрагдсан багш, нийгмийн ажилтны хувь
8.8.	ЕБС-ийн сургачдын дунд тамхини хор хөнөөл, тамхинаас гарах зөвлөгөө өгөх цогц сургалт, сурталчилгаа явуулах төлөвлөгөө гаргаж ажиллах	2014-2020	СЭМҮТ НЭМҮТ НИЙСЛЭЛИЙН БСГ	АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭМГ	Явуулсан сургалт, сурталчилгаа, түүнд хамрагдсан багш, есвөр үеийнхний хувь
8.9.	Багш, эрүүл мэндийн сургалтын арга зүйч, нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага, богино хэмжээний кино, Узүүлэн таниулах материал боловсруулж хэвлүүлэх, түгээх	2014-2020	ЭМЯ СЭМҮТ НЭМҮТ	АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭМГ	Батлагдаж хэвлэгдсэн гарын авлага, сургалтын хэрэглэгдэххүүний тоо

8.10.	Өсвөр үеийнхэнд сургалт явуулах “үе тэнгийн сургагч” бэлтгэх сургалт явуулах	2014-2020	НЭМҮТ ХСҮТ СЭМҮТ	БШУЯР, Аймаг, Нийслэлийн БСГ, ТББ	Сургалтын тайлан, сургалтад хамрагдсан “үе тэнгийн сургагч”-ийн тоо
8.11.	Хүүхэд, өсвөр үе, охид, эмэгтэйчүүдийн дунц албан бус сургалт явуулах	2014-2020	БШУЯР	ЭМЯ НЭМҮТ ХСҮТ, СЭМҮТ ТББ	Сургалтын тайлан, сургалтад хамрагдсан хүүхэд, өсвөр үе, охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь
8.12.	Тамхины хор хөнөөлийн талаар шинжлэх ухаан, танин мэдэхүйн хялбаршуулсан кино зэрэг олон нийтэд зориулсан сургалт, сургалтилгааны Материал, боловсрлуулах, хэвлүүлэх, түгээх	2014-2020	ЭМЯ, СЭМҮТ, НЭМҮТ Орон нутгийн ЭМГ	БШУЯР, Албан бус сургалтын төв, орон нутгийн БГ ТББ	Сургалт, сургалтилгааны материалыаар хангагдсан сургалтын байгууллагын хувь
8.13.	Дэлхийн тамхигийн тэмдэглэж тамхины хяналтыг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан байгууллага, хамт олон, хувь хүнийг олон нийтэд сургалчлах ажлыг зохион байгуулах	ЖИЛ бурийн 5-р сар	ЭМЯ СЭМҮТ НЭМҮТ	ДЭМБ	Тамхигийн тэмдэглэж сургалтилгаа явуулсан Аймаг, Нийслэлийн дүүргийн хувь
8.14.	Тамхины хяналтын тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, сургалтилгаа явуулах	2014-2020	ЭМЯ НЭМҮТ СЭМҮТ	Аймаг, Нийслэлийн ЭМГ, Хэв/мэд-н байгууллага, ТББ	Үйл ажиллагааны тайлан
8.15.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны бүх шатны байгууллагуудад тамхигийн орчин бурдүүлж байгаад дэмжлэг үзүүлэх	2014-2020	ССАЖЯ БШУЯР, БСГ, ШУА АУА (Анагаах ухааны академи)	ЭМЯ НЭМҮТ	Тамхигийн бурдүүлэх талаар шийдвэр гаргаж хэрэгжүүлсэн байгууллагын хувь

8.16.	Тамхины хяналтын тухай хууль, Тогтоомжийн Нэлгөөллийн арга хэмжээ зохион байгуулж аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Засаг дарга нарыг оролцуулах	2014-2020	ЭМЯ	НЭМҮТ Аймаг, Нийслэлийн ЭМГ, БСГ	Ухуулга, сурталчилгаанд хамрагдсан Засаг дартын хувь
<b>Стратегийн чиглэл 9.</b> Эрруул мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний зөвлөөгөө өгөх арга зүйн сургалтад сум, өрхийн эмч, эрүүл өгөх үйлчилгээг нэвтрүүлэх					
Тамхи хэрэглэгчийг ипруулж, богино хэмжээний зөвлөөгөө өгөх арга зүйн сургалтад сум, өрхийн эмч, эрүүл мэндийн мэргэжилтийн 70-аас доошгүй хувь нь хамрагдсан байна.					
9.1.	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, нийгмийн ажилтан, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж тамхини хор хөнөөл, тамхини хэрэглээ, дам тамхидалтын улмаас хүний эрүүл мэнд, айл өрх, улс орны эдийн засаг, байгаль орчинд учруулах сөрөг үр дагавар, тамхини хянгалтын бодлого, арга хэмжээ, тамхинаас гарах эмчилгээ, зөвлөгөөний талаар тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авах	2014-2020	БШУЯ ЭМШУИС Анааах ухаан, Сувилхайн сургуулиуд	ЭМЯ СЭМҮТ НЭМҮТ	Сургалтын агуулга, хөтөлбөр шинэчлэгдсэн сургуулийн хувь
9.2.	Тамхинаас гарах эмчилгээ, зөвлөгөө явуулах төлөвлөгөө гарган сургач багш бэлтгэн сурглт, явуулж, үр дүнг тооцож	2014-2020	ЭМЯ СЭМҮТ	ЭМШУИС	Батлагдсан удирдамж
9.3.	Сум, өрхийн эмч, нийгмийн ажилтнуудыг сургалтад хамрүүлж ЭМАШТ-ийн түвшинд тамхи хэрэглэгчийг ипруулэх, тамхинаас гарах талаар зөвлөгөө өгөх арга барилд сургах	2014-2020	ЭМЯ СЭМҮТ НЭМҮТ	ЭМШУИС, Аймаг, Нийслэлийн ЭМГ	Сургалтад хамрагдсан сум, өрхийн эмч, нийгмийн ажилтны эзлэх хувь
9.4.	ЭМАШТ-ийн түвшинд тамхини хэрэглээг ипруулж зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг арга зүйгээр хангаж ажиллах, тамхинд донтох өвчний заслыг нэвтрүүлэх талаар аймаг, дуургийн сэтгэлийн болон донтох эмгэгийн эмч нарт сурглт явуулах	2014-2020	ЭМЯ СЭМҮТ	БШУЯ ЭМШУИС	Сургалтад хамрагдсан дуургийн хувь
9.5.	Тамхинаас гарах эмчилгээнд шаардлагатай орчин үеийн эм, хэрэгсэл, наалтыг импортлох тендер зарлан шалгаруулж тусгай зөвшөөрөл олгох, хангамжийг нэмэгдүүлэх	2014-2020	ЭМЯ СЭМҮТ	ЭМ ханган нийтүүлэх байгууллага	Орчин үеийн эм, хэрэгслийн тоо, төрөл, хүртээмжийн ёсөлтийн хувь
9.6.	Тамхинаас гарахад туслах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх утсан зөвлөгөө өгөх үйлчилгээг аймаг, дүүрэгт ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх	2014-2020	ЭМЯ, СЭМҮТ	ХХЗГ, Нийслэлийн ЗДТГ	Гарсан шийдвэр